



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

“Төлөөлөгч тойрогтоо” уулзалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3, 52.1.9 дэх заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 6.2, 6.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн 2024-2028 оны бодлого, үйл ажиллагааг иргэдэд тайлбарлан таниулах, Төлөөлөгч иргэдийн хамтын ажиллагааг өрнүүлэх зорилго бүхий “Төлөөлөгч-тойрогтоо” уулзалтыг зохион байгуулсугай.

2.“Төлөөлөгч-тойрогтоо” уулзалтын удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3.Уулзалт зохион байгуулахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба (П.Баянбаатар)-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 2025 оны 02 дугаар сарын ~~17~~-ны
өдрийн ~~18~~ дугаар захирамжийн хавсралт

УДИРДАМЖ

“Төлөөлөгч тойрогтоо” уулзалт
зохион байгуулах тухай

Нэг.Зорилго: Чингэлтэй дүүргийн 2024-2028 оны бодлого, үйл ажиллагааг иргэдэд тайлбарлан таниулах, Төлөөлөгч иргэдийн хамтын ажиллагааг өрнүүлэхэд уулзалтын зорилго оршино.

Хоёр.Уулзалтын хамрах хүрээ, хугацаа: Уулзалтыг 2025 оны 03 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд тойрог тус бүрээр зохион байгуулна.

Уулзалтад Чингэлтэй дүүргийн иргэд, аж ахуй нэгж байгууллагууд хамрагдана.

Гурав.Уулзалтын чиглэл: Хурлын Төлөөлөгчид дүүргийн бодлого чиглэл, үйл ажиллагааг тайлбарлан таниулах, тулгамдсан асуудлаар санал солилцох, иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ.

Дөрөв. Уулзалтын зохион байгуулалт:

4.1.Хурлын Төлөөлөгчид батлагдсан хуваарийн дагуу сонгогдсон тойрогтоо ажиллах бөгөөд иргэдэд зар хүргэх, оролцоог хангах, заал танхимын бэлэн байдлыг хангах ажлыг Хороодын Засаг даргын Ажлын албатай Хурлын Ажлын алба хамтран зохион байгуулна.

4.2.Уулзалтыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилах ажлыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулна.

4.3.Хурлын Ажлын алба Хурлын Төлөөлөгчдийг шаардлагатай мэдээ мэдээлэл, ажиллах нөхцөлөөр хангана.

Тав.Уулзалтыг зохион байгуулахад шаардагдах зардлыг Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.

Зургаа. “Төлөөлөгч-тойрогтоо” уулзалтын хуваарь:

№	Тойрог	Хороо	Хугацаа, байршил	Төлөөлөгчдийн нэрс	Нарийн бичгийн нэрс
1	1	1 дүгээр хороо	III/12-ны өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим	С.Баярсайхан Н.Сайнболд Ж.Чимэдцогзол	Э.Рэнцэнжүгдэр

2		3 дугаар хороо	III/13-ны өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим		
3		4 дүгээр хороо	III/14-ний өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Засаг даргын өрөө		
4	2	2 дугаар хороо	III/12-ны өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим	Ч.Болормаа Д.Буянтогтох А.Ганбаатар	П.Сувд-Эрдэнэ
5		5 дугаар хороо	III/13-ны өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим		
6		6 дугаар хороо	III/14-ний өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим		
7	3	7 дугаар хороо	III/12-ны өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим	Б.Батсайхан З.Очирбат Б.Ерөө С.Энхтайван	Н.Ариунсарнай
8		8 дугаар хороо	III/13-ны өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим		
9		20 дугаар хороо	III/14-ний өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны иргэний танхим		
10	4	9 дүгээр хороо	III/13-ны өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим	Т.Уламбаяр С.Уянгазул Ц.Амаржаргал	Б.Болор-Эрдэнэ
11		10 дугаар хороо	III/14-ний өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим		
12	5	11 дүгээр хороо	III/13-ны өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим	Д.Уянга З.Бямбажав Н.Бямбагэрэл	Б.Мядагмаа
13		13 дугаар хороо	III/14-ний өдрийн 09 ⁰⁰ -13 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим		
14	6	12 дугаар хороо	III/13-ны өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим	О.Есөнтөмөр Д.Отгонбаатар Ч.Хонгорзул	Б.Наранзул
15		21 дүгээр хороо	III/14-ний өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, хорооны нэг цэгийн заал		
16	7	14 дүгээр хороо	III/13-ны өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим	Э.Уянга Н.Доржпүрэв Ц.Содхүү Ш.Мөнх-Оргил	Л.Балжинням
17		15 дугаар хороо	III/14-ний өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим		
18	8	16 дугаар хороо	III/13-ны өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим	Б.Мөнхбат Д.Ядамжав	Л.Ариунзаяа

19		22 дугаар хороо	III/14-ний өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, Нийтлэг үйлчилгээний газрын хурлын заал	Ш.Нарантунгалаг Б.Нямдорж	
20	9	17 дугаар хороо	III/13-ны өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим	Х.Алтаншагай Б.Болортунгалаг А.Лхагвадорж Д.Мөнхтөр	Э.Одончимэг
21		23 дугаар хороо	III/14-ний өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, 17 дугаар хорооны иргэний танхим		
22	10	18 дугаар хороо	III/12-ны өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим	Э.Ганчимэг Л.Цэеэрэгзэн Г.Өлзийбаатар А.Эрдэнэбат	Б.Энххүслэн
23		19 дүгээр хороо	III/13-ны өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, хорооны Иргэний танхим		
24		24 дүгээр хороо	III/14-ний өдрийн 13 ⁰⁰ -17 ⁰⁰ цагт, Цагдаагийн хэсгийн хурлын заал		